

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/003/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энхдэлгэр

Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.15 № 109

танай _____ -ны № _____ -т

**АЛТАЙ УСАН СПОРТ
ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ГАЗАР УТҮГ-ЫН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЗОЛЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг гаргасан боловч эрх бүхий байгууллагаар батлуулаагүй ажилласан байна.

Тайлант онд Эрчим хүчний зохицуулах зөвлөл болон ширээний теннис, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 3 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлого олсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлсэн 81,811.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020308

Өмнөх онд үүссэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй 37,799.1 мянган төгрөг, оны эхний үлдэгдэл 4,941.8 мянган төгрөг, тайлант онд нэмж үүссэн 15,978.9 мянган төгрөг, нийт 59,179.8 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актын дагуу бүртгэсэн байна.

Бусад асуудал

Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 зорилт, 27 арга хэмжээний хэрэгжилтийг 89.4 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,195,223.95	714,290.64
1.1.2	Дансны авлага	200,000.00	-
1.1.6	Бараа материал	22,358,950.00	27,779,180.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,754,173.95	28,493,470.64
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,078,151,412.81	4,124,832,602.51
1.2.2	Биет бус хөрөнгө	23,112,500.03	118,514,318.29
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,101,263,912.84	4,243,346,920.8
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,125,018,086.79	4,271,840,391.44
2.1.1.1	Дансны өглөг	13,194,411.00	59,175,968.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,194,411.00	59,175,968.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,194,411.00	59,175,968.80
2.3.1	Өмч: - төрийн	4,199,545,086.84	4,199,545,086.84
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(87,721,411.05)	13,119,335.80
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,111,823,675.79	4,212,664,422.64
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	4,125,018,086.79	4,271,840,391.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	81,519,967.00	111,282,300.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,623,435.00	
3	Нийт ашиг (алдагдал)	77,896,532.00	111,282,300.00
4	Түрээсийн орлого	7,609,332.00	-
8	Бусад орлого	377,279,400.00	662,231,997.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	362,858,461.47	337,808,213.04
10	Ерөнхий ба удирдлагын зардал	124,215,432.22	420,659,290.16
12	Бусад зардал	6,465,537.00	1,927,458.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(30,754,166.69)	13,119,335.80
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(30,754,166.69)	13,119,335.80
27	Орлогын нийт дүн	(30,754,166.69)	13,119,335.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	466,408,699.00	631,820,771.90
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	81,519,967.00	124,344,571.90
	Татаас, санхүүжилтын орлого	377,279,400.00	507,476,200.00
	Бусад мөнгөн орлого	7,609,332.00	-
1.2	Мөнгөн зарлага (-)	466,050,747.84	632,301,705.21
	Ажиллагчдад төлсөн	162,070,291.00	257,133,588.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	47,742,946.41	75,233,719.53
	Бараа материал худалдан авахад төлсөн	81,323,630.00	69,916,586.00
	Ашиглалтын зардалд төлсөн	149,266,426.43	157,997,640.78



	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,436,350.00	220,000.00
	Татварын байгууллагад төлсөн	14,598,267.00	24,196,733.00
	Бусад мөнгөн зарлага	9,612,837.00	47,603,437.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	357,951.16	(480,933.31)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	357,951.16	(480,933.31)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	837,272.79	1,195,223.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,195,223.95	714,290.64

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,199,545,086.84			(56,967,244.36)	4,142,577,842.48
Залруулсан үлдэгдэл	4,199,545,086.84			(56,967,244.36)	4,142,577,842.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(30,754,166.69)	(30,754,166.69)
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,199,545,086.84			(87,721,411.05)	4,111,823,675.79
Залруулсан үлдэгдэл	4,199,545,086.84			(87,721,411.05)	4,111,823,675.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				13,119,335.80	13,119,335.80
Өмчид гарсан өөрчлөлт				87,721,411.05	87,721,411.05
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,199,545,086.84			13,119,335.80	4,212,664,422.64

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэтрэлт-	Хувь
Үйл ажиллагааны орлого	81,000,000.00	103,912,100.00	(22,912,100.00)	128.3
Түрээсийн орлого	6,000,000.00	7,370,200.00	(1,370,200.00)	122.8
Санхүүгийн дэмжлэг	467,204,000.00	507,476,200.00	(40,272,200.00)	108.6
Бусад орлого		154,755,797.00	(154,755,797.00)	
ОРЛОГО	554,204,000.00	773,514,297.00	(219,310,297.00)	139.6
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг				
1.3 Нийт ашиг		773,514,297.00		
Үндсэн үйл ажиллагаа	540,307,926.00	758,467,503.20	(218,159,577.20)	140.4
Бусад	13,896,074.00	1,927,458.00	11,968,616.00	13.9

1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	554,204,000.00	760,394,961.20	(206,190,961.20)	137.2
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	-	13,119,335.80	(13,119,335.80)	
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-	13,119,335.80	(13,119,335.80)	
Татвараас чөлөөлөгдөх зардал	-	-		
Татвар төлөх ашиг алдагдал	-	13,119,335.80	(13,119,335.80)	
3.1 Орлогын татварын зардал	-	-		
4. Татварын дараах ашиг алдагдал	-	13,119,335.80	(13,119,335.80)	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулсан алдаа

Аудитаар 8,269.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

Борлуулалтын орлого 8,269.5 мянган төгрөгийг бусад орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар залруулагдаагүй нийт 790.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 790.0 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

1. Ажилтнаас 250.0 мянган төгрөгийн урьдчилгаа илүү суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтанд буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

2. Орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 540.0 мянган төгрөгийг өмч хувьчлалын орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн нь Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2023 оны 56 дугаар "Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх, түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнийг тогтоох журмыг шинэчлэн батлах тухай" тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3-т "Түрээслүүлэгч байгууллага орон нутгийн өмчийн түрээсийн орлогын 40 хувийг аймгийн Төрийн сангийн өмч хувьчлалын орлогын 100050000961 тоот дансанд, 60 хувийг тухайн түрээсэлж буй байгууллагын дансанд тус тус төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн өмч хувьчлалын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Албан шаардлага

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, тооллого чанаргүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	Борлуулалтын орлого 8,269.5 мянган төгрөгийг бусад орлогоор бүртгэсэн.	1	8,269.5			1	8,269.5	1	8,269.5				
Дүн		1	8,269.5			1	8,269.5	1	8,269.5				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	Ажилтнаас 250.0 мянган төгрөгийн урьдчилгаа илүү суутгасан. Орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 540.0 мянган төгрөгийг өмч хувьчлалын орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн.	1	250.0	1	250.0	-	-	-	-	-	-

	Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, тооллого чанаргүй байна.	1	-	-	1	-	-	-	-
	Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшингийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна.	1	-	-	1	-	-	-	-
Нийт		4	790.0	2	790.0	1	-	1	-

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн											Үүнээс:	
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		Тоо	Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс түүвэрчилж үзэхэд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 57,228.3 мянган төгрөгийн дүнтэй 5 зарлагыг мэдээлээгүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	
Нийт		1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Өөрчлөлтэй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ОНӨҮГ		1			1				
	НИЙТ		1			1				